






# Та өөрт таалагдаж буй нэг зургийг сонгоорой





Таны хувьд амьдрал бол эрх чөлөө,  
адал явдал юм. Аливаад санаа бага  
зовохыг хичээдэг, алиа хөгжилтэй зан  
тань бусдыг өөртөө татдаг байна.  
Шинэ зүйлийг мэдрэх, дасан зохицох  
нь танд хэцүү төвөгтэй байдаггүй.  
Харин танд ямар нэгэн зүйлээс  
хамааралтай байх нь тухгүй байдлыг  
бий болгодог.




Та бол биеэ даасан, ямар нэгэн зүйлд баригдахгүй байхыг эрхэмлэдэг хүн юм. Та өөрийнхөөрөө шийдвэр гаргаж, бусдыг аялдан дагахгүй, итгэл үнэмшилдээ үнэнч байж чаддаг. Энэхүү зургийг сонгосон хүмүүс урлагийн мэдрэмж нэлээдгүй хөгжсөн байдаг.



Та өөртөө итгэлтэй хүн бөгөөд  
бусдын итгэлийг дааж чаддаг хүн.  
Бусдын олж харж чадаагүй өнцгөөс  
сэтгэж, бодит үнэлээмжийг өгч  
чаддаг давуу талтай. Дэгжин,  
тансаг атлаа чөлөөт байдлыг  
эрхэмлэдэг. Амьдралдаа мөрдөх соёл,  
хандлага таны хувьд маш чухал.




Та амьдралын мөчүүдийг нандин байлгахыг эрхэмлэдэг хүн. Бусадтай танилцааж, харилцаа үүсгэхэд танд ямар нэгэн саад тулгардаггүй. Гэсэн хэдий ч та ганцаараа байхыг эрхэмлэж, аливааг эргэцүүлэх дуртай. Та өөрийн гэсэн орон зайд бий болгон түүндээ өөрийнхөөрөө байж чаддаг.




Та өөртөө итгэлтэй, аливааг хийсвэр зүйлд найдахаас илүүтэй өөрийн тань үйл хөдлөл, шийдвэрээс шалтгаална гэж үздэг учраас удирдлагыг гартаа байлгахыг эрхэмлэдэг. Мөн та итгэл даах, хариуцлагатай хүн учраас асуудлыг шийдэл гаргалгааг олох тийм ч хэцүү биш байdag.




Та тайван, эрч хүчээр дүүрэн хүн юм.  
Хүмүүс тантай ярилахдаа таатай  
байдаг. Ойр дотны, чухал  
хүмүүстэйгээ байхдаа хамгаалагдсан,  
аюулгүй мэдрэмж авдаг. Биеэ авч явах  
хэв маяг, өдөр тутмын хэмнэлээ  
энгийн байлгахыг эрхэмлэдэг.



Та өөртөө дүгнэлт хийж тунгаан, эргэцүүлэх дуртай хүн юм. Хувийн орон зай болон хүрээлэн буй хүмүүсийнхээ талаар та бодолд их автдаг ба амархан хувирч өөрчлөгддөг хүмүүст дургүй. Найз нөхдийнхөө харилцаанд сэтгэл хангалуун байж чаддаг ба үүнээс та тайван байдлыг мэдэрч чаддаг.



Та бол мөрөөдөл, зорилго бол амьдралын салшгүй нэг хэсэг гэж үздэг чөлөөт сэтгэлгээтэй хүн юм. Бусдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг сайн ойлгож чаддаг. Харилцаа холбоо үүсгэх нь танд тийм ч төвөгтэй байдаггүй бөгөөд тантай байхдаа хүмүүс тайвшралыг мэдэрдэг.



Та нэгэн хэвийн, уйтгартай байдалд дургүй бөгөөд экстраверт төрлийн хүн. Шинэ зүйлийг турших, эрсдэлтэй алхам хийх нь танд тийм ч хэцүү байдаггүй. Харин ч үүнээс та амьдралын таашаал, эрч хүчээ олж авдаг идэвхтэй хүн юм.